

ГАРЧИГ

1	Төслийн танилцуулга.....	3
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2	Төслийн 2025 оны уулын ажлын товч төлөвлөгөө	4
2	Орон нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	6
2.1	Өмнөговь аймгийн Баян овоо сумын Налих багийн Байгаль орчны төлөв байдлын товч танилцуулга	6
2.2	Өмнөговь аймгийн аймгийн Баян овоо сумын Налих багийн нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	7
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	8
3.1	Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	8
3.2	Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	9
3.3	Хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээ.....	10
3.4	Гадаргын усанд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	10
3.5	Газрын доорх усанд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	10
3.6	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	11
3.7	Ургамлан нөмрөгт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	11
3.8	Амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	12
3.9	Орчны физик үзүүлэлтэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ	12
3.10	Түүх, соёлын дурсгалд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ	12
3.11	Төслийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	13
4	2025 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	15
5	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
6	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	22
7	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
8	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	23
9	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
10	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	24
11	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
12	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	25
13	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	29
14	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	29
15	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ.....	30
16	Тайлангийн хавсралтууд:	31

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт.....	3
Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим.....	4
Хүснэгт 3. Хөрс хуулалт, олборлолтын хэмжээ	5
Хүснэгт 4. Хүн ам ба малын тоо толгойн өөрчлөлт	7
Хүснэгт 5. Уурхайгаас тоосжилт үүсэх эх үүсвэрүүд болон тоос үүсэх нөхцөл.....	9
Хүснэгт 6. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний төсвийн хураангуй	15

Зургийн жагсаалт

Зураг 1. Лицензийн талбай болон уурхайн байршил	4
---	---

1 Төслийн танилцуулга

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Мөнх ноён суварга ХХК нь Тайланд улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Banpu Public Company Limited ХХК-ийн охин компани бөгөөд, анх 1983 оны 5-р сарын 16-нд "Бан Пү Коал Компани Лимитед" нэртэйгээр байгуулагдсан. Олон улсын бизнест 40 жилийн туршлага хуримтлуулсан Банпу нь одоогоор Тайланд, Индонези, Хятад, Австрали, Лаос БНАСАУ, Монгол, Япон, Америкийн Нэгдсэн Улс, Вьетнам зэрэг улсад үйл ажиллагаа явуулдаг олон улсын эрчим хүчний олон талт үйлчилгээ үзүүлэгч компани юм.


Монгол улс дах үйл ажиллагааг Өмнөговь аймгийн Баян-Овоо суманд байрлах “Цант уул” уурхайд явуулж байгаа бөгөөд уг уурхай нь 2013 оноос хойш үндсэн үйл ажиллагаа явуулаагүй, зогсонги байдалтай байсан хэдий ч тухайн жил бүрийн байгаль орчин, орон нутагт чиглэсэн үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулж ирсэн бөгөөд, компаний зүгээс энэ хугацаан дах үйл ажиллагааны хүрээ зөвхөн байгаль орчин, орон нутгийн иргэдийн нийгмийн хариуцлагийн хүрээнд явагдсаар ирсэн.

Төслийн үйл ажиллагаа нь өнгөрдөг тайланд онуудад явах төлөвлөгөө гарсан ч тухайн цаг үеийн байдал нь Ковид-19 цар тахлаас болж зогсонги байдал нь үргэлжилсэн.

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“Мөнх ноён суварга” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Зайсан, “Тэгээнтэн цогцолбор” 202-р байр, 1502 тоот. Утас: (976)-7555-1221, 7555-1331
3	Төслийн нэр	Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт орших Цант-Уул чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах “Мөнх ноён суварга” ХХК
4	Төсөл хэрэгжүүлэгчийн хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт	1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9011190142 регистрийн дугаар: 5314577 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-016872
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбай	Талбайн хэмжээ: MV-016872 – 67992.5 га
6	Ордын геологийн (A+B+C) нөөц	Нүүрс: 27.7 сая.тн
7	Уурхайн жилийн хүчин чадал	Нүүрс: 1.5 сая.тн

Төслийн байршил: “Цант-Уул” чулуун нүүрсний ордын лицензийн талбай нь Монгол орны өмнөд хэсэгт Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Налих багийн нутагт дэвсгэрт оршдог. Үндсэн үйл ажиллагаа тус Налих багийн Үнэгэд нэртэй газарт явуулж байна. УБ хотоос урагш 610 км, сумын төвөөс баруун хойш 45 км, Даланзадгад хотоос зүүн урагш 126 км-т тус тус оршино.



Зураг 1. Лицензийн талбай болон уурхайн байршил

1.2 Төслийн 2025 оны уулын ажлын товч төлөвлөгөө

Цант уурхай нь 2013 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй зогсонги байсан бөгөөд 2025 оноос үндсэн үйл ажиллагаагаа явуулж эхлээд Уулын ажлын төлөвлөгөөг холбогдох Ашигт Малтмал Газрын Тосны Газараар (Хүснэгт 3)-ийн дагуу батлуулан, энэхүү Байгаль орчны менежмент төлөвлөгөөг холбогдох хууль журмын дагуу боловсруулсан болно.

2025 онд уурхайн ууын ажил 350 хоногт 1407.0 мян.тн нүүрс олборлож ажиллана. Жилд ажиллах хоногийн тоог дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

Үзүүлэлт	Нэгж	Хэмжээ
Жилд ажиллах календарь хоног	хоног	350
Хоног дахь ээлжийн тоо	ээлж	2
Ээлжийн үргэлжилэх хугацаа	цаг	12
Ээлж эхлэх хугацаа	цаг	0.5
Ээлж дуусах хугацаа	цаг	0.5
Цайны цаг	цаг	1
Ээлжинд ажиллах цаг	цаг	10

2025 оны уулын ажлын төлөвлөлтөөр 4756.07 мян.тн хөрс хуулах бөгөөд үүнээс нүүрстэйгээ нийлээд нийт 5761.1 мян.тн уулын цул төлөвлөв.

Хүснэгт 3. Хөрс хуулалт, олборлолтын хэмжээ

Үзүүлэлт	Нийт хөрс хуулалтын төлөвлөгөө, мян.м ³	Нийт нүүрс олборлолтын төлөвлөгөө, мян.тн	Нийт уулын цул, мян.м ³
1-р сар	396.5	53.0	434.4
2-р сар	396.5	84	456.5
3-р сар	396.5	90	460.8
4-р сар	396.5	120	482.2
5-р сар	396.5	120	482.2
6-р сар	396.5	140	482.2
7-р сар	396.5	140	496.5
8-р сар	396.5	140	496.5
9-р сар	396.5	140	482.0
10-р сар	396.5	140	482.2
11-р сар	396.5	130	488.9
12 - р сар	396.5	130	488.9
Нийт	4756.07	1407.0	5761.1

Хайгуул, өрөмдлөг, тэсэлгээний ажлын товч төлөвлөгөө

2025 онын уулын ажлаар хөрс хуулалт болон өрөмдлөг тэсэлгээний ажил хийнэ. Нийт 98276 тууш метр өрөмдлөг хийж 3,705 сая м³ уулын цулд тэсэлгэний ажил төлөвлөсөн. Тэсэлгээнд нийт 1186 тн АНФО болон эмульсын тэсрэх бодис хэрэглэнэ.

2 Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

2.1 Баян овоо сумын Байгаль орчны төлөв байдлын товч танилцуулга

Уур амьсгал: Уг төслийн талбай орчимд хавар, намартаа сэрүүн, зундаа халуун, өвөлдөө хүйтэн, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Энд хавар нь маш хуурай бөгөөд салхи ихтэй. 1976-2019 оны ажиглалтын мэдээнээс үзэхэд тус бүс нутгийн жилийн дундаж агаарын температур 7.4°C , хөрсний дундаж температур 9.6°C байна. Агаарын дундаж харьцангуй чийгшил 39.2%, хур тунадасны дундаж хэмжээ 76.1 мм. Төслийн талбай орчмын салхины дундаж хурд 5.3 м/с, их хурд 33.2 м/с (2015.08) хүрч салхилж байжээ. Тус бүс нутагт баруун зүгийн салхи зонхилдог. Салхины чиглэлийн давтамж сар бүрээр хоорондоо харилцан адилгүй байна. Агаарын сарын үнэмлэхүй их, бага температурын олон жилийн дундаж хэмжээ нь тухайн орон нутаг дахь боломжит хязгаарыг илтгэдэг. 1976-2019 оны ажиглалтын мэдээгээр үнэмлэхүй хамгийн бага температур нь -31.5°C (2002.12), үнэмлэхүй хамгийн их температур нь 42.2°C (2010.07) хүрсэн байна. Зуны улиралд хөрсний хамгийн их температур нь 57°C (1999.07), өвлийн улиралд -27.1°C (1977.01) тус тус ажиглагдаж температурын агууриг 84.1°C хүрсэн.

Гадаргын болон газар доорх ус: Төслийн талбай ба түүний ойр орчимд тогтмол урсгалтай гол, горхи байхгүй. Хуурай сайр, тойрмууд нь хур тунадас ихтэй үед усаар дүүрээд богино хугацаанд хөрс болон агаарт ууршин шингэдэг. Хүн малын усны хэрэгцээнд голлон гар ба гүний худгийн ус хэрэглэнэ. Төслийн талбайгаас 10 км радиуст буюу нөлөөллийн бүсэд гадаргын уст цэг байхгүй (Улсын усны тооллогын 2003 оны шинэчлэгдсэн дүн, Монгол орны гадаргын усны мэдээ, 2011). Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүс дэх голын сүлжээний нягтшил нь $0.01 \text{ км}^2/\text{км}^2$ -ээс бага, гол мөрний нийлбэр урсац $0.5 \text{ л/с} \cdot \text{км}^2$ -аас доош, хур борооны үерийн хамгийн их урсац 10 мм-ээс ихгүй, шар усны үерийн хамгийн их урсац 4 мм-ээс бага, дулааны улирал дахь гадаргын усны ууршилт 1400 мм-ээс их байдаг.

Хөрсөн бүрхэвч: Төслийн талбай нь нүүрсний орд талбай бөгөөд уг талбай нь говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Хур тунадас ховор, эрс гандуу уур амьсгалтай, өвс ургамал тачир сийрэг. Хөрс үүсэх явц гандуу нөхцөлд явагдах учир салхины үйл ажиллагаа хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж, ууршилтыг ихэсгэн хуурайшихад нөлөөлж өвс ургамлыг хийсгэн тараах тул зөвхөн үндэсний зарим нь ялзмаг болдгоос органик үлдэгдлийн хэмжээ маш бага, 1%-иас бараг үл хэтэрнэ. Иймээс сайр чулуу ихтэй хуурай хагсуу карбонатлаг байдгаас нийтлэг мараалаг шинж ажиглагддаггүй.

Ургамлан нөмрөг: Говийн цаг уур, хөрсний онцлогоос шалтгаалан ургамлын нягтшил багатай, сийрэг тачир хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй, энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, шарилж, таана, мангир, хөмүүл, Монгол өвс, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, чихэр өвс, цулхир, гоёо зэрэг эмийн ургамал, хайлаас, тоорой, сухай, заг, жигд, зэгс, зээргэнэ, бударгана, хармаг, харгана гэх мэт модлог говь цөлийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирдэг.

Амьтны аймаг: Баян-Овоо сумын нутагт хээр цөл, говийн ба хуурай хээрийн амьтад зонхилно. Энд говь цөлийн туурайтан амьтдаас хар сүүлт зээр, махчин амьтдаас хярс, үнэг, жигүүртнээс тас, элээ, ногтруу, хэвлээр явагчдаас зарим зүйл гүрвэл, могой, мэрэгчидээс бор туулай зэрэг амьтад тохиолдоно.

2.2 Өмнөговь аймгийн аймгийн Баян овоо сумын Налих багийн нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Малчдын амьдралын гол эх үүсвэр ноолуур учраас ямааг түлхүү өсгөсөн нь харагдаж байна. Өмнөговь аймаг нь Монгол Улсын 21 аймгийн хамгийн том газар нутагтай аймаг ба засаг захиргааны нэгжийн хувьд 15 сум, 53 багтай. Өмнөговь аймгийн Баян-Овоо сум нь газар нутгийн хэмжээгээрээ 15 сумаас гуравт (15.2 мян.кв.км) ордог бол 2010 онд хийсэн хүн амын тооллогоор 3522 хүн тоологдож аймгийн хэмжээнд хүн амын тоогоороо мөн адил гуравт орсон байна.

Хүснэгт 4. Хүн ам ба малын тоо толгойн өөрчлөлт

Үзүүлэлт	2002	2006	2008	2012	2016	2020
Суурин хүн амын тоо	2,306	2,418	2,577	2,901	3,022	3,522
Малын тоо толгой	69,3	52,76	62,256	71,285	102,456	96,084

Баян-Овоо сумын өрхүүдийн үндсэн орлогын эх үүсвэрийг авч үзвэл нийт өрхийн 30.2 хувь нь уул уурхайн салбарын үйл ажиллагаа, 24.8 хувь нь мал аж ахуйн салбарын үйл ажиллагаа, 19.4 хувь нь уул уурхайгаас бусад салбарын цалин, хөлстэй үйл ажиллагаа, 13.9 хувь нь өрхийн хувийн үйлдвэр, үйлчилгээ, 8.7 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, 3.1 хувь нь бусад үйл ажиллагаа байна. Эндээс уул уурхайн салбар нь өрхийн орлогын нилээд хувийг бүрдүүлж байгаа нь харагдаж байна. Багийн түвшинд авч үзвэл, Налих багийн өрхүүдийн орлого уул уурхайгаас хамгийн их, мал аж ахуйгаас бага хамааралтай байна.

3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол нөлөөлөл. Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь урт хугацааны хүчтэй нөлөөлөл байх юм. Энэ нь төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

Газрын хэвлийгээс ашигт малтмалыг олборлох бүх арга технологиуд газар ба түүний хэвлийг хөндөж, экологийн тэнцвэртэй байдалд шууд ба дам байдлаар төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд их эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлдэг онцлогтой. Голлох сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас нийт 246.97 га талбай шууд сөрөг нөлөөлөлд эрчимтэй өртөнө;
- Тус ордыг ил уурхайн технологиор олборлох бөгөөд төслийн хүрээнд нийт 28393.2 мян.м³ уулын ажил хийгдэнэ;
- Газар ба түүний хэвлийг хөндөж ландшафт, гео-орчин, экологийн тэнцвэртэй байдалд шууд ба дам байдлаар төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд эрчимтэйгээр нөлөөлнө
- Уурхайн барилга, байгууламж, уурхайн дотоод, гадаад зам, үерийн шуудуу суваг зэрэг техноген нөлөөллүүд үүснэ;

Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртөх газрын гадаргын талбайн хэмжээг сөрөг нөлөөллийн төрлөөр ангилан үзүүлэв.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Хаягдал чулуулгийн овоолгоос хур бороо ихтэй жилд нүүрс болон түүнийг агуулж буй хурдас дахь металлын сульфид ил гарах буюу, чулуулаг сийрэгжсэнээр агаар дахь хүчилтөрөгч болон усны нөлөөгөөр хүчиллэг урсац үүсч газрын гадарга хэвлийг бохирдуулах магадлалтай. Тус ордын нүүрсний дээжинд хийсэн шинжилгээний дүнгээс харахад нийт агуулагдах хүхрийн хэмжээ ордын дунджаар 1.11% байгаа нь хүчил үүсэх магадлал бага байгааг харуулна.
- Нүүрс бутлан ангилах үйлдвэр болон нүүрсний агуулах ил уурхайн зүүн, зүүн хойд талд 17.4 га талбайд байгуулагдах бөгөөд нүүрсний нарийн ширхэгтэй тоос үүсэн газрын гадаргууг бүрхэн бохирдуулж болзошгүй. Мөн хур бороо ихтэй үед нүүрсний агуулахын талбайд хадгалагдаж буй нүүрсэнд агуулагдаж буй хүнд метал (Be, B, F, Cl, V, Cr, Mn Co, Ni, Cu, Zn, As г.м) угаагдан доош нэвчиж газрын хэвлийг, газрын доорх усыг бохирдуулах эрсдэлтэй.
- ШТМ-ийг тээвэрлэх, юүлэх, хадгалалтын горим алдагдах үед асгаралт үүсч газрын гадарга хэвлийг бохирдуулах магадлалтай
- Уурхайн ажилчдын хотхон, уурхайн бусад барилга байгууламжуудаас гарсан хатуу хог хаягдлаар газрын гадаргыг бохирдуулах, салхи, усаар зөөгдөн ойр орчмын газрын гадаргыг бохирдуулах,
- Хүнд машин механизмын засварын газар, зогсоолын талбай орчмын

газрын гадарга бохирдож болзошгүй байна

3.1 Агаарын чанарт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол нөлөөлөл: Үйл ажиллагааны үеэр ил уурхайн хөрс хуулалтын ажил, нүүрс олборлох, уурхайн дотоод зам зэрэг үйл ажиллагаанаас гол нөлөөлөл бий болно.

Цант-Уулын чулуун нүүрсний ашиглалтын нийт хугацаанд 21.9 сая.м³ хөрс хуулж, хөрсний 2 гадаад овоолгод хураана. Хөрсний гадаад овоолгын талбайн хэмжээ 91.6 га, хөрс тээврийн зай уурхайн ашиглалтын жилүүдэд дунджаар 1.5 км байна. Цант-Уулын чулуун нүүрсний ордын нүүрст давхаргын олборлолтын ажилд мөн өрөмдлөг-тэсэлгээтэй технологи ашиглана.

Хаягдлын овоолгод салхины элэгдэлд өртөмтгий буюу нарийн ширхэгтэй нүүрсний ширхэглэгүүд, чулуулгийн тоосонцрууд агуулагдана. Бүс нутгийн ууршилтын түвшин жилд 50-100 мм (Үндэсний атлас, 2009) байдаг нь ХЧО-ын гадаргуугийн чийг богино хугацаанд хатаж, уурших нөхцлийн бүрдүүлнэ. Улмаар хавар, зуны салхи ихтэй, халуун хуурайшилт ихтэй нөхцөл нь тус овоолгын гадаргуугийн салхины элэгдлийг улам бүр идэвхижүүлж тоосжилтыг хэмжээ, тархах талбайг нэмэгдүүлэх хүчин зүйл болно.

Болзошгүй нөлөөлөл: Нүүрсний ордыг ашиглах явцад уурхайн эдэлбэр газар, ХЧГО, шимт хөрсний овоолго, уурхайн технологийн зам, уурхайн ажилчдын суурин, үйлдвэрлэлийн талбай зэргээс тоосжилт үүсч болзошгүй юм. Тиймээс эдгээр байгууламжуудаас үүсч болзошгүй тоосжилтын хэмжээг тооцов. Төслийн үйл ажиллагааны туршид тоосжилт бий болох талбайг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5. Уурхайгаас тоосжилт үүсэх эх үүсвэрүүд болон тоос үүсэх нөхцөл

Эх үүсвэр	Тоос үүсэх нөхцөл	Тоосжилт ихээр үүсэх нөхцөл
Ил уурхай	Хөрс хуулалт, ухалт, ачилт, буулгалт зэрэг үйл ажиллагааны үед тоосжилт үүснэ.	Уурхайн үйл ажиллагааны үед хөрс хуулалт болон нүүрс ачилт, буулгалтын үед тоос ихээр үүснэ.
Хөрсний овоолгууд болон нүүрсний агуулах, нүүрс боловсруулах үйлдвэр	Хөрс, нүүрсний тээвэрлэлт, буулгалт зэрэг үйл ажиллагаанаас тоосжилт үүснэ.	Шимт хөрсний овоолго болон хаягдал чулуулгийн овоолгыг байгуулах явцад техник хэрэгслийн хөдөлгөөн болон нүүрс, хөрс буулгах үйл ажиллагаанаас тоосжилт ихээр үүснэ.
Уурхайн технологийн зам	Уурхайн замд тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас тоосжилт үүснэ.	Уурхайн хөрс, нүүрс тээврийн зам нь мөн тоосжилтын томоохон эх үүсвэрүүдийн нэг юм. Салхи ихтэй үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс их хэмжээний тоосжилт үүснэ.
Ажилчдын суурин	Ажилчдыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүснэ.	-
Ажлын бусад шороон зам	Хүнд даацын техникхэрэгсэл болон хөнгөн тэрэгний хөдөлгөөнөөс тоосжилт үүснэ.	Техник хэрэгслүүд олноор зорчих болон салхи ихтэй үед замын суларсан шороо салхинд хийсч, тоосжилт ихсэнэ.

Цант-Уул ил уурхайн талбайгаас хамгийн ихдээ хоногт 1987.2 кг тоос үүсэхээр байна. Хуурайшилттай буюу салхины хурд 6 м/с-ээс дээш байх үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, болон овоолгоос тоос тархаж орчны тоосжилтын хэмжээ нэмэгддэг. Тухайн төсөл хэрэгжиж буй бүс нутагт 6 м/с-ээс дээш салхитай өдрийн тоог хамгийн их утгаар авбал жилд 59 өдөр

байна. Үүнээс уурхайн үйл ажиллагаанаас жилд үүсэх тоосжилтын хэмжээг тооцвол 117.2 тн/жил байна.

3.2 Хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээ

Цант-Уул уурхай хамгийн их хүчин чадлаараа ажиллаж байх үед хөрс, нүүрс тээвэрт зорчих нийт 45 техник хэрэгслээс 1 цагт 2457.57 кг нүүрстөрөгчийн хий ялгарахаар байна. Өдөрт 24 цаг ажиллахад 110590.65 кг нүүрс төрөгчийн хий ялгарах тооцоотой байна.

Мөн хөнгөн тэрэгнээс: 1 ш аж ахуйн тээврийн хэрэгсэл 1 км зам туулахад 485.2 грам CO_2 ялгаруулах буюу өдөрт 100 км зам туулахад 48 кг CO_2 үүсгэхээр байна.

3.3 Гадаргын усанд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол сөрөг нөлөөлөл

Цант-Уул нүүрсний ордыг ашиглах явцад ил уурхайн ухаш, хаягдал чулуулгийн овоолго зэрэг байгууламжууд бий болсноор уурхайн баруун талаар орших уулсаас эх авах гадаргын түр урсцын голдрилуудыг хааж байна. Энэ нь хур борооны үед үүсдэг гадаргын урсцын байгалийн горимыг алдагдуулж байгаагаас гадна үерийн хамгаалалтын далан-шуудуугаар урсцын өнгөрөлтийг нэмэгдүүлж шинээр сайр, гуу жалга үүсгэх гол сөрөг нөлөөллийг үзүүлнэ.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Цант-Уул нүүрсний уурхайн үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтын барилга байгууламж барих үед хэрэглэгдэх барилгын материал (цемент), тэдгээрт агуулагдах химийн бодисууд, засварын газар, ШТМ-ын агуулах, машины зогсоол, техникийн нөхцөлийн хувьд хэвийн бус хүнд даацын машин механизм, автомашинуудаас тос, тосолгооны материалууд асарч болзошгүй бөгөөд энэ тохиолдолд хур тунадас болон үерийн усаар угаагдан голдрилуудын хурдсыг бохирдуулах, улмаар гадаргын болон газрын доорх усны чанар, найрлагад сөргөөр нөлөөлж болзошгүй.

3.4 Газрын доорх усанд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол сөрөг нөлөөлөл

Цант-Уул ордыг ашиглах явцад ил уурхайн эргэн тойрны газрын доорх усны 23 м зузаантай уст үеийг бүрэн хатаахаар байна. Тухайлбал төслийн үйл ажиллагааны эхний 3 жилд уурхайд орж ирэх усны хэмжээ хоногт 84 м³ байна, 4-7 дахь жилд хоногт 192 м³ байна.

Газар доорх усыг удаан хугацаанд олборлон ашигласнаас малчдын худгуудын усны түвшин буурах, нөөц багасах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн тосгоны бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны менежментийг оновчтой хийгээгүйгээс эвдрэл гэмтэл үүсэн ахуйн бохир ус хөрсөнд шингэн газрын доорх усанд нөлөөлж болзошгүй юм.

Уурхайн гадаад овоолгын хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж улмаар гадаргын болон газар доорх усанд нөлөөлж бохирдол бий болгох, хүчиллэг урсац үүсгэж болзошгүй.

Ил уурхай, уурхайн гадаад овоолго зэрэг байгууламжуудын төлөвлөлтийг оновчтой хийгээгүйгээс газар доорх усыг бохирдуулах, хомсдуулах шалтгаан болж болзошгүй. Мөн уурхайн ажилчдын хотхоноос гарах бохир усыг хуримтлуулах, зайлуулах үйл ажиллагааны доголдлоос бохир ус хүрээлэн буй орчинд тархаж, тухайн нутаг дэвсгэрийн газар доорх усанд нэвчиж бохирдуулах эрсдэлтэй.

Газрын гүнд нүүрсний давхаргатай хамт пирит (FeS_2)-ийн давхарга байх тохиолдол байдаг. Пирит нь хүчилтөрөгчтэй урвалд орохоороо төмрийн гидроксид болон хүхрийн хүчил үүсгэдэг. Үүссэн хүчил нь орчны хүчил шүлтийн орчныг алдагдуулдаг тул байгаль орчинд асар сөрөг нөлөөтэй. Уурхайн үйл ажиллагаа, хаягдал чулуулгийн овоолгоос хүчил үүсгэх боломжтой тохиолдолд болон бохирдуулагч агуулсан тоос, түүний хуримтлал нь төслийн талбай болон түүний ойр орчмын нутаг дэвсгэрийн хөрс, гадаргын болон газрын доорх усанд нөлөөлж болзошгүй юм.

3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол сөрөг нөлөөлөл

Цант-Уулын ордод 2011 оноос эхлэн олборлолт явуулж эхэлсэн бөгөөд энэ хугацаанаас эхлэн хөрсний эвдрэл үүссэн. 2017 оны байдлаар төслийн талбайд ил уурхайн нээлт, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн гадаад овоолгууд үүсгэх, нүүрсний ачилт буулгалтын талбай, уурхайн тосгон барих бусад дагалдах үйл ажиллагаанаас 142.3 га талбайн хөрс дарагдах, хуулагдах, ухагдах, шилжих зэргээр эвдрэлд өртсөн байна.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

- Уурхайн авто машины засварын газрын үйл ажиллагаа болон ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөний явцад шатах тослох материалаар хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй
- Түлшний агуулах, шатахуун түгээгүүрээс агуулах савны бүрэн бүтэн байдал хангаагүйгээс болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас үүдэн хөрсөн бүрхэвч дээр асгаралт үүсч бохирдуулах

3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол сөрөг нөлөөлөл

Цант-Уул нүүрсний орд ашиглах төслийг хэрэгжүүлсэний үр дүүнд нийт 246.97 га талбайн ургамлан бүрхэвч талхлагдах, дарагдах, устах зэрэг хүчтэй сөрөг нөлөөлөлд өртөнө.

Хөрс хуулалт, нүүрс болон хөрс ачих, буулгах, мөн тээвэрлэх үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим буурах

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Уг тоосжилт нь үйл ажиллагааны туршид жилийн аль ч улиралд, 24 цагийн турш үүсэж болзошгүй бөгөөд энэ нь ойр хавийн нутагт тархан хөрс, ургамлан нөмрөгийг доройтуулах гол хүчин зүйлийн нэг болно.

Тоосжилтоос төсөл хэрэгжих орчны ургамлан нөмрөгт үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь салхиар зөөгдөх болон агаараас буух тоосны хуримтлал юм. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоос нь ургамлын эд эсүүд дээр унаж, урт удаан хугацаанд хуримтлагдан ургамлыг үхүүлэхэд хүрч болзошгүй. Тухайлбал Ил уурхайгаас хөрс хуулал, нүүрс олборлох, тээвэрлэх, ХЧГО, шимт хөрсний овоолго, ахуйн хэрэглээнээс гарсан хуурайшсан хаягдлаас их хэмжээний тоос үүсэхэд нэлээд өргөн нутаг дэвсгэрийг хамран зөөгдөж, тухайн нутаг дэвсгэрийн ургамлан нөмрөгт шууд нөлөөлөл үзүүлнэ. Төслийн талбайн өмнө, зүүн өмнө болон зүүн хойд хэсгүүдэд ийм байдлаар тоосны хуримтлал явагдвал навчны фотосинтезийн процесст саад учруулах нөгөө талаас хүчил үүсгэх боломжтой тоос нь хөрсний хүчиллэгийн хэмжээг ихэсгэж, түүнийг байгалийн ургамлыг тэжээн тэтгэх нөхцөлгүй болгох аюултай.

Төслийн үйл ажиллагаанаас үүсч буй тоосжилт ургамлан нөмрөгт хэрхэн сөргөөр нөлөөлж болзошгүй талаар уг тайлангийн Ургамлан нөмрөгт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ хэсэгт дэлгэрэнгүй тусгасан.

Машин техникийн эвдрэл болон засварын газраас шатах, тослох материал асгарсанаар ургамлын физиологийн хэвийн үйл ажиллагаа алдагдах зэрэг болзошгүй нөлөөллүүд байна.

3.7 Амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Гол сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагааны улмаас тухайн нутгийн орчимд ургамлын ногоон масс багасаж, хөл газрын ургамал зонхилоход хүрэх тул туруутан амьтны хувьд тохиромжтой үндсэн байршил нутаг болж чадахгүй. Улмаар салхин доор нь байх байршил нутагт найрлага нь өөрчлөгдсөн агаар, тоосонд дарагдсан бэлчээр амьдрах орчныг нь улам доройтуулан дайжуулах нөлөө үзүүлнэ.

Болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн хашааны хэвийн бус байдлаас нүх, ухаш, шуудуунд мал, амьтан орж гэмтэх, үрэгдэх асуудал гарч болзошгүй. Уурхайн ажилчид урхи, хавх тавих зэргээр хууль бус ан хийж болзошгүй.

3.8 Орчны физик үзүүлэлтэд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Нүүрсний орд ашиглах төслийн үйл ажиллагааны үед үүсэх дуу чимээ нь ихэвчлэн хөрс хуулах, нүүрс олборлох, тээвэрлэлт буюу уурхайг ашиглах явцад ашиглаж байгаа машин техникүүдийн хөдөлгүүрээс үүснэ.

3.9 Түүх, соёлын дурсгалд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ

Уурхайн үйл ажиллагааны явцад археологийн болон түүх, соёлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй.

3.10 Төслийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Сумын төсөвт төвлөрөх сан болон хамтын ажиллаганы нөлөөгөөр төслөөс Сумын нийгэм эдийн засагт шууд болон дам байдлаар ихээхэн ашиг, тустай төсөл юм. Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөлөл нийгэм эдийн засагт байхгүй.

Нөлөөллийн бүсэд амьдардаг иргэдийн нийгмийн байдал

Нөлөөллийн бүсэд нүүрсний уурхайн талбайгаас 10 км-ийн радиус доторх айлууд байна.

2011 онд төслийн нөлөөллийн бүсэд нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг 17 өрх бүртгэгдсэн, 2013 оны хээрийн судалгаагаар 4 айл, өрх бүртгэгдсэн ба эдгээр өрхүүдээс гадна бүртгэгдээгүй өрхүүдийн нүүлгэн шилжүүлэх хөтөлбөрт хамрагдсан байдал болон нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдаагүй иргэдийн нийгэм, эдийн засгийн байдалд уг төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүдийг дээрх үндсэн хэсэг тус бүр дээр тодруулан тусгав.

ашигт малтмалыг олборлох явцад үүссэн хоосон орон зайд мал, амьтан унаж эрсдэх, мал бэлчээрлэхэд хүндрэл учирч болзошгүй.

Төслийн хүрээнд ажиллаж байгаа ажилтан ажиллагсад санамсар болгоомжгүйгээр нутгийн малчин иргэдийн ашигладаг худгийн усыг бохирдуулах улмаар чанар, найрлагыг өөрчилснөөр малчдын дунд усаар дамжин өвчлөл тархаж болзошгүй.

Ил уурхай орчимд баригдсан барилга байгууламжууд, шинээр замын сүлжээ үүссэнээр малын бэлчээр доройтох, ус хангамжийн хүрэлцээгүй байдал, нутгийн малчин иргэдийн дунд ус хангамж, бэлчээр ашиглалттай холбоотой маргаанууд гарч болзошгүй.

Хүн амын төвлөрөл нэмэгдсэнээр согтууралт, гэмт хэргийн гаралт болон бэлгийн замын халдварт өвчин гарах тохиолдол нэмэгдэж болзошгүй,

Нүүрс тээврийн авто замын дагуу хог хаягдал үүссэнээр орчныг бохирдуулах, нутгийн иргэдийн амьдрах орчинд тааламжгүй байдлыг бүрдүүлэх,

Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал

- Цант-Уул уурхайн орчмоос үүссэн тоосжилтоос агаарт агуулагдах тоосжилтын хэмжээ нэмэгдэх улмаар уурхайн ажилчид, Баян-Овоо сумын оршин суугчид болон нутгийн малчин иргэдийн дунд амьсгалын замын өвчлөл нэмэгдэх,
- Тоосжилт болон төслийн үйл ажиллагаатай холбоотой тээвэр зөөврийн машин техникийн хөдөлгөөнөөс үүссэн тоосжилтоос малын ноос, ноолуур зэрэг түүхий эд бохирдон чанар буурч зах зээлийн ханшаас доогуур үнэлэгдэх улмаар малчдын орлогын түвшин буурахад нөлөөлөх,
- Төслийн үйл ажиллагаатай холбоотой дуу шуугиан нь нутгийн иргэдэд тавгүй байдал үүсгэх улмаар эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй,
- Төслийн хүрээнд ажиллаж байгаа ажилтан ажиллагсад санамсар болгоомжгүйгээр нутгийн малчин иргэдийн ашигладаг худгийн усыг бохирдуулах улмаар чанар, найрлагыг өөрчилснөөр малчдын дунд усаар дамжин өвчлөл тархаж болзошгүй,

- Хүн амын шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдэж, сумын эрүүл мэндийн газрын ачаалал нэмэгдэх, улмаар иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учирч болзошгүй.

Гол сөрөг нөлөөлөл

Нүүрсний ил уурхай олборлолт, нүүрсний тээвэрлэлт

- Төслийн талбай бэлчээр ашиглалтын талбайгаас шахагдсаны улмаас ашиглалтын талбайгаас гадагш бэлчээрийн даац хэтрэх, мал бэлчээрлүүлэх талбай хомсдох
- Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу чимээ, доргион, тоосжилт төслийн талбайгаас 10 км зай дотор амьдардаг нутгийн иргэд болон төслийн ажиллагсдын эрүүл мэнд, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх,

Ил уурхайнуудын олборлолт, хаягдал чулуулгийн овоолго, олборлосон нүүрсийг ил уурхайгаас тээвэрлэх, хадгалах талбайд буулгах, ачих ачих, тээвэрлэх, ус тунаах цөөрмийн далангаас салхины элэгдлээр бохирдол агуулсан тоосжилт үүссэнээр нөлөөллийн бүс дэх болон нөлөөллийн бүстэй ойр нутагладаг малчин өрхүүд болон төслийн ажиллагсдын эрүүл мэнд, амьдрал ахуйд сөргөөр нөлөөлөх

4 2025 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Цант уул уурхайн үндсэн үйл ажиллагаа эргээд сэргэсэнтэй холбоотойгоор 2025 онд байгууллагын Тогтвортой хөгжлийн бодлогод тулгуурлан Усны нөөц баялгийг хамгаалахад чиглэсэн байгаль орчны менежментийн гол зорилт бол төлөвлөлт, үйл ажиллагаагаар дамжуулан нөлөөллүүдийг аль болох багасгах, арилгах, сөрөг нөлөөллийг төслийн талбайн хил хязгаараар хязгаарлах буюу ойролцоох газар нутгийг хамруулахгүй байх явдал байна.

Тус байгаль орчны менежмент төлөвлөгөө нь “Мөнхноён Суварга” ХХК-ийн Цант-Уул нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- Байгаль орчны ауди, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх.
- Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.
- Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах.
- Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарах.
- Компанийн байгаль орчны бодлого, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах.
- Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтын байдалд хяналт тавьж, төрийн болон хяналтын байгууллагуудад мэдээ хүргэх.
- БОМТ-нд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг тодорхойлох.
- ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах.

Хүснэгт 6. Байгаль орчны менежмент төлөвлөгөөний төсвийн хураангуй

Бүлгийн №	Байгаль орчныг хамгаалах чиглэл	Хийгдэх ажлын тоо	Төлөвлөгдсөн төсөв (төг)
